



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ ХАРААТ БУС АУДИТЫН ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ,  
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ**

**Нэг. Журмын зорилго, хамрах хүрээ**

- 1.1. Монголдаатгал ХК-ийн (цаашид “Компани” гэх) санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээд (цаашид “гүйцэтгэгч” гэх)-ийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээг дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2. Энэхүү журам нь Даатгалын тухай хууль, Аудитын тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 1.3. Энэхүү журам нь “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний загвар бүхий хавсралтаас бүрдэнэ.

**Хоёр. Гүйцэтгэгчийг сонгох, сонгон шалгаруулах үе шат**

- 2.1. Гүйцэтгэгчийг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан сонгон шалгаруулна.
- 2.2. Гүйцэтгэгчээр Сангийн яамнаас олгосон аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй, түүнчлэн Санхүүгийн Зохицуулах хорооноос олгосон даатгалын байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээтэй хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгоно.
- 2.3. Гүйцэтгэгчийг сонгохдоо худалдан авах үйл ажиллагааны хялбаршуулсан хувилбар болох харьцуулалтын аргыг хэрэглэнэ.
- 2.4. Сонгон шалгаруулах үйл явц нь дараах үе шатаас бүрдэнэ.
  - 2.4.1. Санхүүгийн зохицуулах хорооноос зарласан даатгалын байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хараат бус аудитын хуулийн этгээдүүдийн жагсаалтаас өмнөх хугацааны санхүүгийн тайлангийн аудитын ажлын чанарын үнэлгээнд үндэслэн 5-аас дээш жил ажилласан нэр хүнд бүхий 5 аудитын байгууллагын жагсаалт гаргах;
  - 2.4.2. Сонгосон байгууллагуудад ажлын даалгавар илгээж, ирүүлсэн саналыг ажлын даалгаварт заасны дагуу үнэлнэ.
  - 2.4.3. Ажлын даалгаварт саналыг үнэлэх техникийн болон үнийн шалгуур үзүүлэлт, оноог дараахь жишгээр тусгайлан заана.

Оноо	Үзүүлэлт
20	Оролцогчийн санал болгож буй аудитын ажлын хөтөлбөр болон аргачлал нь захиалагчийн ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал

10	Оролцогч нь ажлын даалгаварт заасан аудитын ажлыг гүйцэтгэж байсан туршлага
10	Оролцогчийн голлох мэргэжилтнүүдийн чадвар болон туршлага
10	Томоохон харилцагчдын жагсаалт
50	Үнийн санал

2.4.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь оролцогчдын ирүүлсэн саналыг нээж, тухайн оролцогчдын саналыг үнэлж эрэмблэх ба хамгийн сайн санал өгсөн байгууллагаас эхлэн гэрээний нөхцлийг хангуулах хэлэлцээр хийнэ.

2.4.3. Шалгарсан оролцогчтой гэрээний нөхцөлөөр харилцан тохиролцоонд хүрээгүй бол дараагийн өндөр оноо авсан оролцогчтой хэлэлцээр хийнэ.

2.5. Гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах

2.5.1. Шалгарсан оролцогчтой хийсэн хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд Компани уг оролцогчтой гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

2.5.2. Гэрээ байгуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгоно.

2.5.3. Компани гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногт багтаж гэрээ байгуулна.

#### **Гурав. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах хэлбэр, хугацаа**

3.1. Компани нь эрх олгогдсон гүйцэтгэгчтэй “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г байгуулна.

3.2. “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ” нь байгуулагдсанаас хойш нэг жилийн хугацаатай байх ба аудитын ажлын чанарын хяналтын үнэлгээнд үндэслэн гэрээ сунгагдах эсэхийг шийдвэрлэнэ. Гэрээ сунгах нийт хугацаа нь 3 жилээс илүүгүй байна.

3.3. Компани гэрээ байгуулахын өмнө ажлын даалгаварт гүйцэтгэгчээр хийлгэх аудитын ажлын зорилго, цар хүрээ нь зохистой, хангалттай хэмжээнд тусгагдсан эсэхийг сайтар шалгаж, ажлын даалгаварт нөлөөлөхөөргүй нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

#### **Дөрөв. Гэрээнд талуудын хүлээх эрх, үүрэг**

4.1. Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээнд Компани дараахь эрх, үүрэг хүлээнэ.

4.1.1. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Даатгалын багц дүрмийн дагуу бэлтгэж, тогтоосон хугацаанд гүйцэтгэгчид ирүүлэх, аудит хийлгэх;

4.1.2. Гүйцэтгэгчийн шаардсан аудиттай холбоотой, тайлан, тооцоо, санхүүгийн баримт, мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт материалыг саадгүй гаргаж өгөх;

4.1.3. Гүйцэтгэгчийг үйлчлүүлэгчийн ажлын байранд ажиллах нөхцөл бололцоогоор хангах;

4.1.4. Үйлчилгээний нийт төлбөрийн 50 хувийг аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан төлөх, 30 хувийг аудитын тайланг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан төлөх, үлдэх 20 хувийг Компанийн аудитлагдсан санхүүгийн тайланг

Санхүүгийн зохицуулах хороонд хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан гүйцэтгэгчид төлөх;

4.2. Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээнд гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.2.1. Аудитын тухай хууль, санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага, аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, энэ журам болон холбогдох бусад дүрэм, журмын дагуу ажиллах;

4.2.2. Аудитын ажил эхлэхээс өмнө аудитын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, хөтөлбөрийг Компаниар хянуулах;

4.2.3. Аудитын явцад Компанийн санхүүгийн ажилтантай байнгын харилцаатай байж, аудитын явц, эрсдэл болон горимын талаар мэдээлж, асуудлыг нотолж хэлэлцэх;

4.2.4. Гүйцэтгэгч аудитын ажил гүйцэтгэж дууссанаас хойш аудитын ажлын баримт материалыг өөртөө хадгалах бөгөөд Аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д заасны дагуу 10 жилийн хугацаанд ажлын болон нотлох баримт материалыг хадгалж, шаардлагатай үед үзэх боломжийг Компанид олгох;

4.2.5. Аудитын төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатанд гүйцэтгэгчийн хяналтыг Чанарын Хяналтын Олон Улсын Стандарт 1 болон бусад холбогдох стандартын дагуу хийж гүйцэтгэх;

4.2.6. Аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагын саналд гүйцэтгэгчийн удирдлагын тайлагналын үе шатны хяналтыг чанартай хийж гүйцэтгэх, тайлангийн тоо дүн, агуулгатай холбоотой алдаагүй тайланг захиалагчид хүлээлгэн өгөх;

4.2.7. Аудитын ажлыг дуусгавар болгосноор баримт, материалуудыг захиалагчид хүлээлгэн өгөх;

4.2.8. Аудитын үйлчилгээний төлбөрийн урьдчилгаа 50 хувийг "Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ" байгуулсанаар, 30 хувийг аудитын тайланг хүргүүлж хянаж баталснаар, 20 хувийг аудитлагдсан санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хороонд хүлээн авснаар Компаниас нэхэмжлэх;

#### **Тав. Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлт, аудитын ажлын чанарыг дүгнэх**

5.1. Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо үнэлэх бөгөөд аудитын тайлан, зөвлөмж, акт албан шаардлагыг гэрээнд заасан хугацааны дотор хүлээлгэн өгсөн байх, аудитаар илрүүлсэн зөрчлийн ач холбогдол, үр дүн, илрүүлэлтийг үндэслэл болгоно.

5.2. Аудитын ажлын чанарыг Санхүүгийн зохицуулах хорооны дүгнэлийг үндэслэн Аудитын хороо тогтооно.

5.2. Аудитын ажлын гэрээний үүргийн биелэлт, чанарын үзүүлэлт өндөр байх нь гэрээг сунгах үндэслэл болно.

----oO----